



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД УХНААГИЙН ХҮРЭЛСҮХИЙН ИВЭЭЛ ДОР
“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ - ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ”
УЛСЫН ХОЁРДУГААР ЗӨВЛӨГӨӨН - 2018




ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЗАРДЛЫН НОРМ НОРМАТИВ, САНХҮҮЖИЛТИЙН ШИНЭЧЛЭЛ

Илтгэгч:



САЛБАРЫН ТӨСӨВ



778
сургууль

Төрийн болон орон
нутгийн өмчийн

645

Нийслэлд **128**
Орон нутагт **514**


Төрийн бус өмчийн

133

Нийслэлд **94**
Орон нутагт **38**



САЛБАРЫН ТӨСӨВ





САЛБАРЫН НОРМ НОРМАТИВ

Зардлын зүйл	ЕБС
Хувьсах зардал/нэг хүүхдэд жилд дундажаар мян.төг/	
Сум, аймгийн төв	437.9
Нийслэл	374.0
Дотуур байр	387.5
Хоол /өдөрт/	
Дотуур байрны хүүхдийн хоол /өдөрт/	2.315
Үдийн цай /өдөрт/ 1-5 анги	0.600
Тусгай сургуулийн үдийн хоол /өдөрт/	2.400

Засгийн газрын 2016 оны 242 тоот тогтоол

Засгийн газрын 2012 оны 106 тоот тогтоол

Засгийн газрын 2017 оны 162 тоот тогтоол



ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВ

ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ: БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

40.1.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон **нормативт зардлаар** санхүүжүүлнэ.

40.2.Төрийн өмчит бүх шатны сургууль, цэцэрлэгийн тогтмол зардал, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны нийт зардал, тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардал, цэцэрлэгийн байршлыг харгалзан хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа **нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс** санхүүжүүлнэ.

40.3.Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд **нэг суралцагчид ногдох хувьсах зардлын** хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно.

40.5.**Нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг** сургуулийн байршил, хэв шинж, мэргэжлийн чиглэл, олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн сургалтын онцлог болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан энэ хуулийн 40.3-т заасан сургалтын байгууллага тус бүрээр ялгавартай тогтоох бөгөөд аргачлалыг нь боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

41.3.Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн **нэг суралцагчид төрөөс ногдох сургалтын нормативт зардлын** хэмжээг тухайн боловсролын сургалтын байгууллагын сургалтын төлбөртэй нь уялдуулан Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно.



ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВ

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 242 ДУГААР ТОГТООЛ

ШИНЭЛЭГ ТАЛУУД:

- Хувьсах зардлын бүрэлдэхүүн
- Төрийн бус өмчийн ЕБС-ийн суралцагчийн дундаж норматив
(төлбөр 5.0-10.0 сая бол -40%, 10,0 сая дээш бол -70% бууруулж олгоно.)
- Дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал



ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВЫН ХАМРАХ ХҮРЭЭ

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН СУРГУУЛЬ

- Багшийн үндсэн цалин
- Хөдөө орон нутагт ажилласны, ур чадварын, анги кабинет, заах аргын нэгдэл хариуцсаны зэрэг нэмэгдэл
- Цалин, нэмэгдэлд ногдох байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэл
- Бараа үйлчилгээний бусад хувьсах зардал
- Дотуур байрны багш, ажилтны үндсэн цалин, орон нутгийн нэмэгдэл
- Дотуур байрны бараа үйлчилгээний хувьсах зардал

ТӨРИЙН БУС ӨМЧИЙН СУРГУУЛЬ

- Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ



ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВЫН БҮТЭЦ

Багшийн цалин:

Багшийн албан тушаалын цалин болон нэмэгдэл цалин, хүүхдийн цэцэрлэг, дотуур байрны багш, ажилтнуудын албан тушаалын цалин болон зарим нэмэгдэл

/Зарим нэмэгдэл гэдэгт: цалин, хөдөө орон нутагт ажилласны, ур чадварын, анги кабинет, заах аргын нэгдэл хариуцсаны зэрэг нэмэгдлийг ойлгоно/

Нийгмийн даатгалын шимтгэл:

Багшийн үндсэн болон нэмэгдэл цалинд ноогдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл

Бараа үйлчилгээний бусад хувьсах зардал:

- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх
- Бичиг хэрэг
- Ном хэвлэл
- Шуудан холбоо, интернетийн төлбөр
- Дотоод албан томилолт
- Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс
- Нормын хувцас, зөөлөн эдлэл
- Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл
- Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж
- Бараа үйлчилгээний бусад зардал



ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВ

НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС:

ХҮҮХДИЙН ТОО

СУРГУУЛИЙН БАЙРШИЛ

СУРГУУЛИЙН ХЭВ ШИНЖ

СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН
ХЭМЖЭЭ

НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ
ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ
НОРМАТИВЫН ХЭМЖЭЭ

ТӨРИЙН БУС ӨМЧИЙН СУРГУУЛИЙН ХУВЬД



ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВЫН АРГАЧЛАЛ

- Бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг жилийн дүнгээр батлуулж, орон нутагт эрх шилжүүлдэг бөгөөд **зардал хооронд шилжүүлэх** боломжтой
- Тусгай сургуулийн хувьсах зардлыг **3 дахин нэмэгдүүлж** олгоно.
- Баян-өлгий аймгийн цалингийн зардлыг **4%**, бараа үйлчилгээний бусад зардлыг **3%** нэмэгдүүлж олгоно.
- Цалингийн сангийн хэмжээ нь тооцсон цалингаас **30%** хэтэрсэн тохиолдолд **байгууллага хооронд шилжүүлж** зарцуулах боломжтой.
- Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл урлагийн газар, дүүргийн боловсролын хэлтэс **сар бүр хүүхэд өдрөөр хяналт хийх** үүрэгтэй.



ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВ

- 2.1.3. “санхүүжих дундаж хүүхдийн тоо” гэж сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцоход ашиглан батлагдсан аргачлалын дагуу төсвийн жилд харгалзуулан тооцсон хүүхдийн тоог;

$$AFP_i = \frac{(P_{(i-1,i)} * 6 \text{ сар} + P_{(i,i+1)} * 4 \text{ сар})}{10 \text{ сар}}$$

$AFP_i = i$ онд санхүүжих хүүхдийн тоо

$P_{(i-1,i)}$
= $(i - 1, i)$ буюу Өмнөх оны хичээлийн жилийн хүүхдийн тоо

$P_{(i,i+1)}$
= $(i, i + 1)$ буюу дараагийн хичээлийн жилийн хүүхдийн тоо



ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВЫН ШИНЭЧЛЭЛ

НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВ, БАГШ БУС АЖИЛЛАГСДЫН ОРОН ТООНЫ ЖИШГИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ХУВЬСАХ БОЛОН ТОГТМОЛ ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН СИСТЕМИЙГ БИЙ БОЛГОХ;

Хувьсах зардлын хэмжээг шинэчлэх, санхүүжилтийн аргачлалын батлах тухай Засгийн газрын тогтоол батлуулна.

Хувьсах зардлыг зориулалтын дагуу хуваарилдаг, зарцуулдаг хяналтын системийг бий болгох;

Бараа үйлчилгээний бусад хувьсах зардлын хичээл, практикийн зардлыг нэмэгдүүлэх;

Сургуулиуд хувьсах зардлаар бүрэн санхүүждэг болох;

Бүлэг дүүргэлт нь нормативт хүрэхгүй хөдөөгийн сумын сургуулийн хувьсах зардлын индексийг шинэчилж, санхүүжилтийн хэвийн байдлыг хангах;

Төсөв зориулалтын дагуу зарцуулдаг болно.

Хичээл, практик, хэрэглэгдэхүүний зардал нэмэгдэнэ.

Төсвийн шууд захирагч нарт цалингийн сандаа багтаан цалин хөлсний асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Сангийн сайдын тушаалаар баталсан багш бус ажиллагсдын орон тооны жишиг нормативтай болно.


Багш болон багш бус ажиллагсдын цалингийн санг тусад нь төлөвлөж, санхүүжүүлнэ.



ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВЫН ШИНЭЧЛЭЛ

БАГШИЙН БОЛОН УДИРДЛАГА, АЖИЛТНЫ ЦАЛИНГИЙН САНГ ХООРОНД НЬ ШИЛЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ ХЯЗГААРЛАХ

Удирдлага,
ажилтны
цалингийн
сан




Багшийн
цалингийн сан

- Ажлын ачаалал
- Үр дүн



ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВЫН ШИНЭЧЛЭЛ

БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ХУВЬСАХ ЗАРДЛЫГ
ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ ТАРИФТ НИЙЦҮҮЛЭН НЭМЭГДҮҮЛЭХ



Зайлшгүй
хэрэгцээний
60%-ийг улсын
төсөвт баталж
байна.



ХУВЬСАХ ЗАРДЛЫН НОРМАТИВЫН ШИНЭЧЛЭЛ

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**